



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 12.17 № 03/10343
тагай _____ ны № _____ -Г

**Тендер шалгаруулалтыг
түдгэлзүүлэх тухай**

Танай байгууллагаас зарласан ЫШУЯ/20240101099 дугаартай “Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо/” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Бапкер” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

- 1.Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
- 2.Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
- 3.Батлагдсан тендер шалгаруулалтын баримт бичиг;
- 4.Оролцогчдын ирүүлсэн тендер /Тендер нээх нууц үг/;
- 5.Тендерийн нээлтийн тэмдэглэл;
- 6.Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
- 7.Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
- 8.Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
- 9.Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
- 10.Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг анхаарна уу.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ